

**ЭЦСИЙН БОЛОН ДУНДЫН ЗОГСООЛЫН НИЙТИЙН ТЭЭВРИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА УГСРАЛТ, ШИНЭЧЛЭЛТ, ТОХИЖИЛТЫН АЖЛЫН  
ЕРӨНХИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2024 оны 03 -р сарын 25 өдөр

Дугаар №01

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолыг шинээр барих, шинэчлэх ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гүйцэтгэх.

**Төслийн үндэслэл:** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлах тухай" А/1434 дүгээр захирамж

**Төслийн зорилго:** Улаанбаатар хотын иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг нэмэгдүүлэх.

**Төслийн хүрээнд хийгдэх ажлууд:** Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолын саравч барих

**Ажлын технологийн үндсэн шаардлага:** Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдсэн зураг төслийг үндэслэн ажлыг гүйцэтгэхдээ Авто тээврийн тухай хууль. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Барилгын тухай, Авто замын тухай хууль, Газрын тухай хууль. Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм болон холбогдох БНБД-д заасан норм, шаардлагад нийцүүлэн батлагдсан зургийн дагуу захиалагч, ашиглагчийн шаардлагад нийцүүлэн ажиллах шаардлагатай. Угсралтын ажилд ашиглагдах материалыг төсөвт заагдсан чанарт нийцүүлэн сонгох ба зөвхөн захиалагч байгууллагын зөвшөөрлөөр солино. Захиалагч байгууллагын баталсан ажлын даалгавар, зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу зураг төслийг эрх бүхий байгууллагаар боловсруулан гүйцэтгэх

Зураг төсөл боловсруулахдаа дараах норм дүрэм стандартыг дагаж мөрдөнө.

- Хот. тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-21),
- "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04,
- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01 -06-90/;
- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм,
- "Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал Техникийн шаардлага" MNS5879:2012 стандарт
- Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны "Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах шаардлага" UCS 1601B:2020 стандарт

- “Явган зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”  
MNS 6056:2009

Холбогдох дүрэм журмууд

- Барилга угсралтын ажил гүйцэтгэхдээ дараах норм дүрэм, стандартыг дагаж мөрдөнө.
  - “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй, Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000
  - Орчны аюулгүй байдал 2019 он, UCS0001-01:2019
  - Гадна орчны тохижилт 2019 он, UCS0002-02:2019
  - Иж бүрэн гудамж 2019 он, UCS0001-02:2019
  - Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө 2020 он UCS1404C:2020
  - Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө 2020 он UCS1403C:2020
  - Авто зогсоол БНБД 21.05.10

Ажлын дараалал:

- Холбогдох техникийн нөхцөлүүдийг бүрдүүлэх
  - Ажлын даалгаврын дагуу зураг төсөл боловсруулах
  - Захиалагч байгууллагатай зураг төслийн явцын хяналт хийлгэх
  - Захиалагч болон холбогдох байгууллагуудаар зураг төслийг хянуулж баталгаажуулах
  - Ажлын графикийг батлуулах
  - Барилга эхлүүлэх зөвшөөрөл авах
  - Шаардагдах хэмжилтийн ажлын тооцоог гүйцэтгэж, шинээр барьж байгуулах ажлын байршилтай танилцах
  - Шаардлагатай бол газар чөлөөлөлтийг хийх
  - Батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажлыг эхлүүлэх
  - Ажлыг бүрэн дуусгаж байнгын ашиглалтанд оруулах
  - Гүйцэтгэлийн зураг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж захиалагчид байгууллагад хүлээлгэн өгөх
  - Тухайн төслийг ашиглалтад хүлээлгэн өгөх
- Гүйцэтгэгч дараах шаардлагуудыг хэрэгжүүлж ажиллана:
- Гүйцэтгэсэн ажлыг фото зургаар баталгаажуулж тухайн ажил гүйцэтгэх хугацаанд байнга хяналт хийлгэн акт үйлдэж ажиллах.
  - Дээрх техникийн тодорхойлолт, стандарт шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллага санхүүжилтийг олгохгүй байх, мэргэжлийн хяналтын улсын байцаагч гэрээт ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
  - Гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дэвтрийг өдөр тутам хөтөлж талбайн инженерийн гарын үсгээр баталгаажуулж ажиллана.
  - Дээрх техникийн тодорхойлолтын шаардлагыг биелүүлээгүй, барилга угсралтын ажилд хэрэглэгдэх материалын чанар болон угсралтын ажлын чанар нь зураг төсвийн болон БНБД-ийн шаардлагад нийцэхгүй байгаа тохиолдолд захиалагч байгууллага гэрээ цуцлах, санхүүжилтийг зогсоох, мэргэжлийн хяналтын улсын байцаагч ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
  - Барилгын тухай хуулийн дагуу гүйцэтгэгч байгууллага нь угсралтын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авснаас хойш 3 жилийн хугацаанд чанарын доголдлыг хариуцна.

**НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭЦСИЙН БОЛОН ДУНДЫН ЗОГСООЛЫН  
БАРИЛГА УГСРАЛТ, ШИНЭЧЛЭЛТ, ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗУРГИЙН  
ДААЛГАВАР**

2024 оны 3-р сарын 20 өдөр

Дугаар №01

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлах тухай" А/1434 дүгээр захирамж
2	Барилга байгууламжийн байршил	Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар. Баянзүрх, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хамаарна.
3	Хамрах хүрээ	Гол болон туслах гудамж зам
4	Зогсоолын саравчны төлөвлөлт	Саравчийг нийтийн тээврийн зогсоолын зэрэглэлээс хамаарч 4м, 5м, 8м, 12м-ээс тус бүр багагүй байхаар төлөвлөнө.
5	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан
6	Автобусны зогсоолын байгууламжийн хийц	“Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах ерөнхий шаардлага” UCS 1601B:2022 Автобусны зогсоолын байгууламж: -Металл хүрээ бүхий шилэн хийцтэй саравчийг орчин үеийн дэвшилтэт технологиор хийнэ -Автобусны чиглэлийн электрон мэдээллийн самбар /LED дэлгэц байж болно/ - Дээврийн эргэн тойронд зогсоолын нэр бичигдэнэ -Саравчны дэргэд байрлуулах электрон мэдээллийн самбар - Мэдээллийн нэмэлт самбар - Гэрэлтүүлэг - Камер - Сандал - Хогийн сав

7	Зураг төсөл боловсруулах хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
8	Ажил гүйцэтгэх байгууллага	- Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага.
9	Захиалагч байгууллага	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
10	Ажил гүйцэтгэхэд ашиглах материал	<p>Хууль тогтоомж:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Авто тээврийн тухай хууль,</li> <li>- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль,</li> <li>- Барилгын тухай,</li> <li>- Авто замын тухай хууль,</li> <li>- Газрын тухай хууль,</li> <li>- Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хууль,</li> </ul> <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-21),</li> <li>- “Нийтийн тээвэр Замналын зогсоол, Ангилал. Техникийн шаардлага” MNS5879 2012 стандарт</li> <li>- Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах шаардлага” UCS 1601B:2020 стандарт</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм,</li> <li>- “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101 04,</li> <li>- “Явган зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” ММЗ 6056:2009</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/;</li> </ul> <p>Холбогдолтой бусад норм, дүрэм</p> <p>Стандартууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000</li> <li>- Орчны аюулгүй байдал 2019 он, UCS0001-01:2019</li> <li>- Гадна орчны тохижилт 2019 он, UCS0002-02:2019</li> <li>- Иж бүрэн гудамж 2019 он, UCS0001-02:2019</li> <li>- Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө 2020 он UCS1404C:2020</li> <li>- Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө 2020 он UCS1403C:2020</li> <li>- Авто зогсоол БНБД 21.05.10</li> <li>- Бусад холбогдох хууль, стандарт, норм, дүрэм, заавар;</li> </ul>

11	Зураг төслийн иж бүрдэл	<p>Баримт бичгийн иж бүрдэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Холбогдох техникийн нөхцөлүүд</li> <li>-Зогсоолын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл</li> <li>-Зургийн тайлбар бичиг</li> <li>-Техникийн шаардлага</li> <li>-Ажлын нэр төрөл, тоо хэмжээ</li> <li>-Одоогийн байдал /Фото зургаар баталгаажуулах/</li> <li>-Хэмжилтийн зураг төсөл</li> <li>-Ажлын төсөв</li> </ul>
12	Онцгой нөхцөл	<p>Ажлыг гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар зураг төсөвт тусгаж өгөх, “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах,</p> <p>Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хий, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барих үед геометр хэмжээг хангах хэмжилтийн төсөл даалгавар боловсруулах,</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хөрсний шинж чанараас шалтгаалан суурийг оновчтой сонгох,</li> <li>-Зогсоолын байгууламжийн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх, камержуулах,</li> <li>-Төлөвлөлтийн нөхцөл байдалд тохируулан иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах,</li> <li>-Гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан “LED” технологиор шийдвэрлэх, ажлын зургийг боловсруулах,</li> <li>-Электрон самбар</li> <li>-Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна.Үүнд:</li> </ul> <p>Дэвсгэр зураг 1:500 Дагуу огтлол хэвтээ 1:1000босоо 1:100</p> <p>Хөндлөн огтлол 1:100 Уулзвар. огтлолцол 1:500</p> <p>Бүтэц 1:20</p> <p>Зогсоолын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга, бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш, тоон хэлбэрээр (DWG болон PDF) хүлээлгэж өгнө.</p>
13	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO болон төсвийн зөвшөөрөгдсөн программаар тооцох.

